



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэн ажил  
гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ барилга байгууламжийн жагсаалтаар Эрүүл мэнд, спортын сайдын багцын XVI.2.1.13 Спорт цогцолбор, 700 суудал /Сүхбаатар, Баруун урт сум/-ын ажлын 402,600,000.0 /Дөрвөн зуун хоёр сая зургаан зуун мянга/ төгрөгийн гэрээг шинэчлэн байгуулах, сунгах, цуцлах, нэмэлт тендер зарлах эрхийг Сүхбаатар аймгийн Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т үүрэг болгосугай

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА